210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000.00

2105	Нормативт зардал	148,696.21
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	127,696.21
210502	Хоол, хүнс	19,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,894.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,871.50
210602	Тавилга	2,000.00
210604	Урсгал засвар	9,022.50
2107	Томилолт, зочны зардал	57.70
210702	Дотоод албан томилолт	57.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,200.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,200.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,139.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,035.60
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	180.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,855.60
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	103.50
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	103.50
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	386,152.08
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	386,152.08
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	26,389.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,357.73
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,759.79
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	191,644.96
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	1,080.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,080.00

3. Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Ongon сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга О.Үнэнбор танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 15-аас 2021 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ганцэцэг хариуцаж, Аудитын менежер Г.Даваа, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар чанарын хяналтыг гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Ongon сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 01/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Сүхбаатар аймгийн Ongon сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг амжилттай даван туулж, хүн, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, Орон нутгаа хөгжүүлэх, төрийн бодлогын залгамж чанарыг хадгалахад онцгой анхаарна” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

1. Ковид-19 Халдварт цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулах
2. Ковид-19 цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилт нөөц хангалтыг нэмэгдүүлнэ.
3. Өрсөлдөх чадвартай боловсрол
4. Эрүүл мэндийн төгс үйлчилгээ
5. Хүн амын хөгжил
6. Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт
7. Нийгмийн хамгаалал
8. Хүртээмжтэй эдийн засаг
9. Иргэдийн оролцоотой шинэ сум хөтөлбөр
10. Газар тариалан
11. Хөдөө аж ахуй
12. Хуультай монгол
13. Аюулгүй амгалан монгол
14. Батлан хамгаалах бодлого
15. Нийгмийн аюулгүй байдал

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Онгон сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Онгон сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдахгүй байх зэрэг үр дагавартай байна.

Сүхбаатар аймгийн Ongon сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшин “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Сүхбаатар аймгийн Ongon сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,643.0 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь буюу 36.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 304.5 сая, эцсийн үлдэгдэл 457.9 сая төгрөг болж, 153.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	19.9	45.6	25.7	7
Төрийн сангийн харилцах	438.0	769.2	331.2	93
Хадгаламж	-	-	-	-
Дүн	457.9	814.8	356.9	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Ongon сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 769.2 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 45.6 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансанд сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого 175.1 сая, ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт 127.6 сая, нэмэлт дансны үлдэгдэлд 0.1 сая, эрүүл мэндийн төвийн харилцах дансны үлдэгдэл 1.1 сая, мал аж ахуйн орлого 140.3 сая, 2019, 2020 оны татварын болон татварын бус орлогын үлдэгдэл 215.4 сая, татварын болон татварын бус орлогын давалт 109.4 сая төгрөг тус тус үлдэгдлээр үлджээ.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 171.9 сая, эцсийн үлдэгдэл 191.5 сая төгрөг болж, 19.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Дансны авлага /ТӨҮГ/	3.8	10.8	7
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.09	0	-0.09
Байгууллагаас авах авлага	0.2	99.1	98.9
Зээлийн авлага	167.8	81.6	-86.2
Дүн	171.9	191.5	19.6

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Ongon сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 99.1, Сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 59.6, Засаг даргын тамгын газрын цөөн малтай өрхийг дэмжиж, малжуулах төслийн хүрээнд 3 жилийн хугацаатай, эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээ байгуулсан авлага 22.0, Ongon-Arviжих ОНӨААТҮГ-ийн авлага 10.8 сая төгрөг зэрэг байгаа бөгөөд 0.5 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлага байна.

Авлагын дансны үлдэгдлийн 52% нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага, 31% нь сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага, 11% нь малжуулах төслийн авлага, 5.6% нь Ongon арвижих ОНӨААТҮГ-ын авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагын дансны үлдэгдэлд 2017 онд үүссэн 1 харилцагчийн 0.5 сая төгрөгийн он дамжсан авлага байна. /Ongon арвижих ОНӨААТҮГ/

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 172.2 сая, эцсийн үлдэгдэл 237.3 сая төгрөг болж, 65.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	0	11.1	11.1
Эм боох материал	24.5	44.1	19.6
Түрээсийн сурах бичиг	0	0	0
Бичиг хэргийн материал	2.5	5.6	3.1
Аж ахуйн материал	85.8	107.7	21.9
Сэлбэг хэрэгсэл	0.2	0.2	0
Түлш тослох материал	12.4	10.4	-2
Барилгын засварын материал	0.3	0.3	0
Хүнсний материал	11.1	12.4	1.3
Бусад хангамжийн материал	7.8	18.5	10.7
Мал амьтад	27.6	27	-0.6
Дүн	172.2	237.3	65.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Ongon сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 237.3 сая төгрөг болж 65.1 сая төгрөгөөр өссөн нь өмнөх жилүүдэд сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан Эрүүл мэндийн газарт нэгтгэгддэг байсан ба 2021 оноос сумынхаа санхүүгийн албанд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа нэгтгүүлдэг болсонтой холбоотойгоор Эрүүл мэндийн төвийн бараа материалын үлдэгдэл нийт бараа материал дансны үлдэгдлийг өсгөсөн байна.

Бараа материалын дансны 237.3 сая төгрөгийн үлдэгдлийн 45.4 хувийг аж ахуйн материал эзэлж байгаа бөгөөд сэлбэг хэрэгсэл бусад хангамжийн материал, 18.6 хувийг эм боох материал гол нөлөөлж байна. Мөн бараа материалын үлдэгдлийн 14.0 хувийг Эргэлтийн эмийн сан, 15.6 хувийг Засаг даргын Тамгын газар, 18.1 хувийг Хүүхдийн цэцэрлэг, 19.4 хувийг Эрүүл мэндийн төв, 18.2 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 5.4 хувийг Соёлын төв, 9.3 хувийг Ongon арвижих ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Нийт 14 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 11.0 сая төгрөгийн, 3 хувь хүмүүстэй холбоотой 1.4 сая төгрөгийн худалдан авалт татварын цахим системд

бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй зөрчил дутагдал илэрч, албан шаардлага хүргүүлэв. /Ерөнхий боловсролын сургууль, Ongon арвижих ОНӨААТҮГ/

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,263.9 сая, эцсийн үлдэгдэл 6,558.2 сая төгрөг болж 1,294.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	3,813.50	4,412.30	598.80
Тээврийн хэрэгсэл	226.9	403.8	176.90
Машин тоног төхөөрөмж	252.2	676.2	424.00
Тавилга эд хогшил	192.1	221.9	29.80
Дуусаагүй барилга байгууламж	0	0	0.00
Номын фонд	30.1	13.1	-17.00
Бусад үндсэн хөрөнгө	687.7	758.1	70.40
Программ хангамж	3.8	4.9	1.10
Бусад биет бус хөрөнгө	57.6	67.9	10.30
Бусад хөрөнгө	0.04	0.04	0.00
Дүн	5,263.9	6,558.2	1,294.3

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Ongon сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 83.4, шилжүүлэн авсан 952.3, үнэ төлбөргүй хандиваар авсан 307.9я, нийт 1,343.6 сая төгрөгөөр нэмэгдэж, акталсан 29.1 сая, шилжүүлсэн 20.3 сая нийт 49.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв. /ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, ЗДТГ, ИТХ, Ongon арвижих/

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,621.2 сая, эцсийн үлдэгдэл 1,592.5 сая төгрөг болж, 28.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	21	22.6	1.6	1.4
Ажилчидтай холбогдсон өглөг	0.3	0.1	-0.2	0.01
Байгууллага төлөх өглөг	15	14.7	-0.3	0.92
Татварын өглөг /ТӨҮГ/	5.5	7	1.5	0.44
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0	0	0	0.00
Дансны өглөг /ТӨҮГ/	0	0	0	0.00
Хувь хүмүүст төлөх өглөг	0.2	0.9	0.7	0.06
Бусад урьдчилж орсон орлого	1600.2	1,569.9	-30.30	98.6
Нийт дүн	1621.2	1,592.5	-28.70	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ажилчидтай холбогдсон өглөг 0.1, байгууллагад төлөх 14.7, татварын өглөг 7.0, хувь хүмүүст төлөх өглөг 0.9, бусад урьдчилж орсон орлого 1,569.9, нийт 1,592.5 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Өр төлбөр өндөр байгаа нь Онгон арвижих ОНӨААТҮГ-т үнэ төлбөргүй ирсэн 1,569.9 сая төгрөгийн хөрөнгийг хойшлогдсон орлогоор бүртгэж, жил бүр капиталжуулж байгаа нь өр төлбөрт нөлөөлсөн байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,407.9 сая, эцсийн үлдэгдэл 4,648.6 сая төгрөг болж, 1,240.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № .6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,305.90	1,301.50	-4.40	28.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	13.1	465.4	452.30	10.0
Хуримтлагдсан үр дүн	1,138.30	1,731.10	592.80	37.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	950.6	1150.6	200.00	24.8
Дүн	3,407.90	4,648.60	1,240.70	100.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн 1,731.1 сая төгрөг болж 592.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 541.4 сая төгрөг, мөн тайлант оны үр дүнгээс өмнөх үеийн үр дүнд 51.4 сая төгрөгийн бичилт хийгдсэн байна. Энэ нь 2021 оноос Эрүүл мэндийн төв сумынхаа санхүүгийн албанд жилийн эцсийн тайлангаа нэгтгүүлдэг болсонтой холбоотойгоор өмнөх үеийн үр дүн 54.1 сая төгрөгөөр өсөж, 2020 онд хийгдэх байсан булгийн эх хаших ажил 2021 онд хийгдэж авлага үүсгээгүй байсан учир 2.7 сая төгрөгөөр үр дүнгээ бууруулах алдааны залруулгын бичилт хийгдсэн байна.

3.5.7 Орлогын данс

Татварын болон татварын бус орлого 260.7, зээлийн хүүгийн орлого 2.3, үнэ төлбөргүй хүлээн авсан 314.2, түрээсийн орлого 1.9, борлуулалтын орлого 175.6, бусад орлого 82.5, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 2,121.1, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 126.3, нэмэлт санхүүжилтийн орлого 386.0, орон нутгийн төсвөөс санхүүжих 749.2, нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих 102.8 сая, нийт 4,322.7 сая төгрөгийн орлого бүрдсэн байна.

3.5.8 Зардлын данс

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 2,030.5, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 274.0, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 248.3, хангамж, бараа материалын зардал 94.7, нормативд зардал 258.4, эд хогшил, урсгал засварын зардал 25.5, томилолт, зочны зардал 6.7, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 263.3, бараа үйлчилгээний бусад зардал 294.0, бусад урсгал шилжүүлэг 96.7, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 25.5, үйл ажиллагааны бус зардалд 138.3, нийт 3,781.4 сая төгрөгийн зардал тайлагнасан байна.

Зардлын данстай холбоотой холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй 10.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- *Онгон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2021 оны 12 сарын 16-ны өдрийн Б/07 дугаар захирамжаар тэргүүлэгч болон төлөөлөгчдөд олгосон 6.0 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшууллаас ХХОАТ-ыг суутган төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоов. /ИТХ 0.6 сая/*
- *Хөдөлмөрийн чадвар түр алдсаны акттай 1 ажилтны 1-12 сарын цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцсоноос 0.3 сая төгрөгийг илүү суутгасан, 1 ажилтны 9-12 сарын цалингаас ХХОАТ-ыг тооцож бодоогүйгээс 0.3 сая төгрөгийг дутуу суутгасан зөрчилд төлбөрийн акт тогтоов. /ЕБС 0.6 сая/*
- *Хөдөлмөрийн чадвар алдсаны акттай ажилтны цалингаас НДШ-ийг энгийн ажилтны хувиар тооцсоноос НДШ-ийн 0.7 сая төгрөгийг, ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцсоноос 4.1 сая төгрөгийг, нийт 4.8 сая төгрөгийг илүү суутгасан зөрчилд төлбөрийн акт тогтоов. /ЭМТ 4.8 сая/*
- *Нийт 20 ажилтны цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт тооцохдоо Нийгмийн даатгалын шимтгэлийг хассан дүнгээс суутган тооцолгүй, олговол зохих цалингаас суутган тооцсоноос 0.2 сая төгрөг илүү суутгасан зөрчилд төлбөрийн акт тогтоов. /Онгон арвижих 0.2 сая/*
- *Өвс тэжээлийн нөөцийн агуулах барих төсөл арга хэмжээ нь 2021.09.28 өдрийн СУ-011/21 тоот гэрээнд "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл"-өөр 70 хувь буюу 67.2 сая төгрөг, ОНХС-аар 30 хувь буюу 28.8 сая төгрөгөөр санхүүжигдэхээр заасан байхад ОНХС-аас 30 хувийн санхүүжилтийг 33.0 сая буюу 4.2 сая төгрөгөөр илүү шилжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоов. /ОНХС 4.2 сая/*

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 11 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 79.3 сая төгрөг, татварын бус орлого 13.0 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 201.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 218.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО	92.3	201.7
ТАТВАРЫН ОРЛОГО	79.3	98.2
Хувь хүний орлогын албан татвар	59.0	87.9
Үйл ажиллагааны орлого	4.0	23.3
Хөрөнгийн орлого	37.0	42.1
Шууд бус орлого	18.0	22.5
Хөрөнгийн албан татвар	1.6	1.6
Бууны албан татвар	1.6	1.6
Бусад татвар (төлбөр, хураамж)	18.7	8.7
Улсын тэмдэгтийн хураамж	2.5	2.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8.0	0.8
Газрын төлбөр	7.2	1.3
Ус, рашаан ашигласны төлбөр	1.0	3.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13.0	103.5
Хүү, торгуулийн орлого	13.0	21.0
Бусад орлого	0	82.5

Орон нутгийн татварын орлого 18.9 сая төгрөг, татварын бус орлого 90.5 сая төгрөг нийт 109.4 сая төгрөгөөр давсан нь нөлөөлсөн байна. Үйл ажиллагааны орлого 19.3 сая төгрөгөөр давж орсон нь хувиараа үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүний орлогын татварыг цахим системээр нэхэмжлэх үүсгэдэг болсонтой холбоотой татвар үнэн зөв төлөгдөх болсон, хөрөнгийн орлого 5.1 сая төгрөгөөр давж орсон нь арилжааны банкин дахь иргэдийн мөнгөн хадгаламжийн хэмжээ өссөн, мөн Гялс төгрөг ХЗХ тус суманд үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой хадгаламжийн хүүгийн орлого сумын төсөвт орсноор өсжээ.

Мөн шууд бус орлого 4.5 сая төгрөгөөр давахад 2021 оны ноосны урамшууллын 10 хувь, бусад орлого 82.5 сая төгрөгөөр давсан нь 3 шонхор шувууны орлого төвлөрсөн нөлөөлжээ. Хүү, торгуулийн орлого 8.0 сая төгрөгөөр давсан нь тайлант онд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил гарсантай холбоотой цагдаагийн торгуулийн орлого нэмэгдсэн байна.

Төсвийн төлөвлөлт

Тус Засаг дарга 2021 онд татварын орлогыг 68.7 сая, татварын бус орлогыг 8.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Засаг даргын хүргүүлсэн төсвийн татварын орлогыг 2.6 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Үүнд: Шууд бус орлогыг 3.0 сая, үйл ажиллагааны орлогыг 1.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 3,161.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,755.6 сая төгрөгийг урсгал зардалд, 406.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Гүйцэтгэлээр сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 89.6, орон нутгийн төсвөөс 828.3, тусгай зориулалтын шилжүүлгээс 2,095.8, ОНХСанд олгох орлогын шилжүүлгээс 126.3, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 4.8 сая нийт 3,144.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,049.5 сая төгрөг буюу 87 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдэл төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 26.4 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 75.4, дээд шатны төсвийн захирагчаас 92.6, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 191.6 сая, нийт 386.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 30.7, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 10.0, хангамж, бараа материалын зардалд 16.4, нормативд зардалд 148.7, эд хогшил, урсгал засварын зардалд 21.9, томилолт, зочны зардалд 0.06, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 101.2, бараа үйлчилгээний бусад зардал 6.9, бусад урсгал шилжүүлэг 49.1 сая, нийт 385.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 137 мэдээллээс 124 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс 154 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 50 мэдээллийг мэдээлээгүй тул зөвлөмж хүргүүлэв. /Цэцэрлэг, ЗДТГ, ИТХ, ЭМТ, ЕБС, Онгон арвижих/

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргад төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 сан нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 5 дүгнэлт өгч, орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, соёлын төв болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал нийт 4 газрыг түүвэрт хамруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 43.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 10.4 сая төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 32.8 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага, 0.5 сая төгрөгийн 17 зөвлөмж хүргүүлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар биологийн хөрөнгө болох мал амьтадыг бодит үнэ цэний аргаар санхүүгийн тайланд толилуулах, ОНХС-аар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг ЗДТГ-т бүртгэх бус тус санд нь захиалагчийн зүгээс бүртгэж байгаа байдлыг хамруулан авч үзэхээр төлөвлөж байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Шилэн данстай холбоотой асуудал:

4.1.1 Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 13 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулгын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн

газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

4.2 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:

4.2.1 Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэнийн аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан байна.

4.2.2 Эрсдэл:

НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.3.1 Илрүүлэлт:

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

4.3.2 Эрсдэл:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.НАРАНТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ДАВАА

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Б.ГАНЦЭЦЭГ